



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/421

Чойбалсан

Г

Комисс томилох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Авто замын тухай хуулийн 28.1, 28.4 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоол, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, зохиогч, захиалагчийн хяналт хийсэн тайлан, дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVI.1.1.67 дахь заалтад тусгагдсан "Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт (Дорнод, хэрлэн сум)" ажлын 5 дугаар багц "Булган өндөр" ХХК-ийн гүйцэтгэсэн "Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0,58км авто замын барилга"-ын ажлыг хүлээн авах, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	А.Түмэнжаргал	-Аймгийн Ерөнхий архитектор
Гишүүд:	М.Ганбат	-Аймгийн Засаг даргын тамгын газрын Авто замын хяналтын улсын байцаагч
	Т.Баярмаа	-Аймгийн Архивын хэлтсийн Сан хөмрөгч
	М.Гансүмбэр	-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
	Х.Батсайхан	-Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, хошууч
	Ж.Батнасан	-Зураг төслийн байгууллагын төлөөлөл, "Гео зураглал" ХХК-ийн захирал
	З.Цэндмаа	-Захилагчийн хяналтыг төлөөлж "Танил санаа" ХХК-ийн захирал
	Б.Өлзийбаяр	-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, "Булган өндөр" ХХК-ийн захирал

Комиссын нарийн бичиг:
Б.Урансүх

-Аймгийн Засаг даргын тамгын
газрын Бүс, Орон нутгийн
хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

2.Комиссын үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу "Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0,58км авто зам" ажлыг удирдан зохион байгуулж, ажлын дүгнэлтийг аймгийн Засаг даргад урьдчилан танилцуулсны дараа албан ёсоор баталгаажуулахыг Комиссын дарга (А.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.ЁЛ